



MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 сарын 23-ны өдрийн 11:00 цагт ХУД, 3-р хороонд байрлах Төв дэлгүүрийн дэргэдэх Мираж ресторанд болов. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүд М.Баяр, Б.Нандин-Эрдэнэ, А.Жаргалмаа, ТУЗ-ийн ердийн гишүүд Ж.Оюунчимэг, Ц.Баатарсайхан, Онлайн хариуцсан Дэд захирал О.Мишээл, Борлуулалт дизайн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал Б.Болормаа, Санхүү хариуцсан дэд захирал Б.Энхмандах, Санхүү удирдлага хариуцсан захирал Э.Тод-Од, Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Менежер Уранчимэг, Ахлах аудитор Энхбат нар оролцов.

**ХУРЛЫН НЭЭЛТ**

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Энэ өдрийн мэндийг та бүхэнд хүргэе. Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ, энэ хурлыг зохион байгуулж байгаа болон ажлынхаа тайланг хүргэх гэж байгаа удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд та бүхэнд дахин мэндчилгээ дэвшүүлье. Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болоод байна. Би та бүхэнд хурлыг зохион байгуулж байгаа ажлаа тайлагнах гэж байгаа хүмүүсийн талаар бага зэргийн мэдээлэл хүргэе. Зүүн гар талд сууж байгаа хүмүүс маань манай ТУЗ-ийн гишүүд. Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал, Монгол улсын Хөдөлмөрийн баатар Ц.Баатарсайхан, ТУЗ-ийн хараат бус гишүүн, СЭЗИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, маркетингийн мэргэжилтэй Б.Нандин-Эрдэнэ, хараат бус гишүүн А.Жаргалмаа Гарэ сургууль хөтөлбөрийн удирдагч, олон улсын нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн хүн байгаа. ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн салбарын эрхлэгч, доктор хүн байгаа. Манай хараат гишүүн Ж.Оюунчимэг Таван Богд Группийн маркетингийн газрын захирал. Баруун гар талд манай удирдлагын багийнхан сууж байна. Онлайн хариуцсан дэд захирал О.Мишээл, Борлуулалт дизайн үйлдвэрлэл хариуцсан захирал Б.Болормаа, Санхүү хариуцсан дэд захирал Б.Энхмандах, Санхүү удирдлага хариуцсан захирал Э.Тод-Од, энэ жилийн манай санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийсэн Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Менежер Уранчимэг, Ахлах аудитор Энхбат нар хүрэлцэн ирсэн байна. Энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн хурал онцлог болж байгаа. Жил болгон онцлог байдаг гэхдээ энэ жил тусгайлан онцлог жил байна. 2021 онд бид ажилтнууддаа хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн. Өнөөдрийн байдлаар манай компанийн 1,500 ажилтан хувьцаа эзэмшиж байгаа. Тэдгээрийн маань төлөөлөл орж ирсэн байгаад маш баяртай байна. Та бүхэн засаглалын түвшинд юу болдог, бид ажлаа хэрхэн тайлагнадаг, та бүхний бүтээж байгаа баялгийг илүү үнэ цэнтэй, илүү өгөөжтэй болгохын тулд удирдлагын баг болоод ТУЗ-өөс ямар ажлууд явуулдаг талаараа та бүхэндээ танилцуулахдаа маш их баяртай байна. Энд 50 ажилтан сууж байгаа, онлайн дотоод сүлжээгээр манай бусад ажилтнууд хурлын үйл явцтай дэлгэрэнгүй танилцах боломжтой шууд холбогдоод явж байгаа. Хурлаа эхлүүлэхээс өмнө манай тогтвортой хөгжил хариуцсан А.Цэрэнтогтох захирлыг урьж

байна. Манай компани 2022 ондоо байгаль орчин, нийгэм, засаглал гэсэн тогтолцоог бэхжүүлэхийн төлөө нэлээн их чармайлт гаргаж ажиллах гэж байгаа. Цэрэнтогтох захирлыг хурлын өмнө товч мэдээлэл өгнө үү гэж хүсэж байна.

**Тогтвортой хөгжил хариуцсан захирал А.Цэрэнтогтох:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Говь ХК нь ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэмд үзүүлж байгаа байгаль орчны нөлөөллөө удирдахад гол анхаарлаа хандуулж ажилладаг. Өнөөдрийн миний танилцуулах safety share буюу аюулгүй ажиллагааны мэдээллийг хуваалцах гэдэг үйл ажиллагаагаар хувьцаа эзэмшигчдийн хурал маань эхэлж байгаад туйлын баяртай байна. Говь ХК нэн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Нийт 1,500 гаруй ажилтнуудынхаа эрүүл, аюулгүй ажлын байрыг бүрдүүлэх, тэднийхээ нийгмийн асуудлыг шийдэхэд гол бодлого бас чиглэдэг. Би та бүхэнд энэ слайдаар 2021 оны Говь ХК-ийн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлсэн гол үзүүлэлтүүдийг танилцуулах юм. Ер нь 600 хүнд хохирол, 30 хүнд осолд дөхсөн тохиолдлыг илрүүлээд залруулж чадвал 10 хугацаа алдсан гэмтэл, 1 нас баралтын ослоос сэргийлж чадна гэсэн үндсэн аюулгүй байдлын онол байдаг. Манай компани 2021 онд нийт 507 үл тохирлыг аюулгүй байдлын хяналт шалгалтаар илрүүлж чадсанаар мөн осолд дөхсөн тохиолдлыг осол болохоос өмнө илрүүлж арга хэмжээ авч, хугацаа алдсан гэмтэл 0, нас баралттай осол 0 үзүүлэлттэйгээр ажиллаж чадсан. Байгууллагын хэмжээд 2021 онд нийт 273 өдөр ажилласан, нийт 3,407,040 хүн цаг үйлдвэрлэлийн осолгүй, хугацаа алдсан гэмтэлгүйгээр ажиллаж чадлаа. 2021 оны гол зорилт бол үйлдвэрлэлийн ослыг 0 түвшинд барина гэсэн зорилттой ажилласан. Хугацаа алдсан гэмтлийн давтамж бол 1 сая цаг тутамдаа 0 байдлаар удирдаж чадсан байна. Энэ өөрөө Говь ХК ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд анхаарч, ач холбогдол өгч чаддагийн нэгэн илрэл болжээ гэж мэдээлэхээр зорьсон. Миний танилцуулах хэсэг энэ байлаа, баярлалаа.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** А.Цэрэнтогтох захиралд баярлалаа. Бид одоо хурлаа эхлүүлэхээс өмнө ирцийн мэдээг зайлшгүй авах ёстой болдог. Тооллогын комиссын дарга Н.Сайнзулыг урьж байна, ирцийн мэдээллийг өгнө үү.

## 1. ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ

*Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.*

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул бүртгэлийн өдрөөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 байгаагаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр 284,538,863 саналын эрхтэй 1,046 хувьцаа эзэмшигч, өнөөдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 405,499,195 саналын эрхтэй, нийт 95 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт хурлын ирц 88.45% болсон тухай хурлын даргад мэдэгдэж, хурлын ирц Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасан тул хурлын дарга хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.



## 2. ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ

*ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.*

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Н.Сайнзул даргад баярлалаа. Хурлын ирц хангалттай байгаа учир хурал өөрөө хүчин төгөлдөр байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээснийг та бүхэнд мэдэгдье. Одоо хурлын дэгийг танилцуулъя. Хурлын үргэлжлэх хугацааг 2 цаг гэж төлөвлөсөн байгаа. Хэлэлцэх асуудлуудаа дарааллаар нь та бүхэнд хэлье:

1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
4. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
  - 4.1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
  - 4.2 ТУЗ-өөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
  - 4.3. Хувьцааны ханш, ногдол ашиг
  - 4.4. ТУЗ-ийн 2021 оны ажлын тайланг танилцуулах
5. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт
6. Саналын хуудсаар санал авах
7. Завсарлага /Санал хураалтын дүнг нэгтгэх/
8. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтэн танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах
9. Хурлаас гарах тогтоолын төсөлд санал асуулгын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Бид бүхэн хурлаа цагтаа эхлээд цагтаа дуусгахыг чухал гэж бодож байна. Энэ ажлыг чухал гэж бодоод цагаасаа өмнө, цагтаа ирсэн хувьцаа эзэмшигч нартаа талархал илэрхийлье. Эрт ирээд хурлын материалтайгаа танилцаад сууж байсан хүмүүс надад сайхан санагдлаа. Одоо би та бүхний өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ-г урьж байна. Тооллогын комисс томилсон тогтоолыг танилцуулна.

## 3. ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ

*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.*

**ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Тооллогын комиссын даргаар Дотоод аудитын хэлтсийн дарга Н.Сайнзул, нарийн бичгийн даргаар Үйлдвэр бүртгэлийн албаны дарга Ц.Цэцэгбадам, гишүүдээр Ахлах аудитор Н.Мөнхзул, Хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Уянга, Программын төслийн менежер Г.Ганзаяа, Үйлдвэр хариуцсан нягтлан бодогч Г.Золзаяа гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдон ажиллаж байна. Эдгээр хүмүүс маань өнөөдрийн хэлэлцэж буй асуудалтай ямар нэгэн холбоотой эрх бүхий албан тушаалтан биш байгаа гэдгийг онцолж хэлмээр байна. Баярлалаа.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** М.Сэлэнгэ-д баярлалаа. Дэгийнхээ дагуу дараагийн асуудалдаа оръё. Эхний тайлан болох 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнгийн тайланг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан танилцуулна.

## 4. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

### 4.1 Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах

*Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан танилцуулав.*

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эхний сандлууд хоосон байна хойно байгаа хүмүүсээс урагшаа ирээд сууна уу. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд 2020, 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ковидоос болоод онлайнаар хийж байсан. 2022 ондоо ковидын нөхцөл байдал арай гайгүй болоод биеэр уулзаж байгаадаа баяртай байна. 2021 онд болсон үйл явдлынхаа тухай ярья:

#### 2021 оны онцлох үйл явдал:

- 2019 оны сүүлээр Говь ХК 2,600 ажилтантай байсан. 2020 оноос эхлээд үсрэнгүй хөгжлийн үе эхлэх гэж байтал 2020 оны 1 сараас эхлээд ковид гараад, харамсалтай нь 2,600 гаруй байсан ажилчдын тоогоо 1,500-1,600 болоод 1,500 ажилтандаа өнгөрсөн оны намар хувьцаа эзэмшүүлсэн байгаа.
- Говь ХК үүсгэн байгуулагдсаны 40 жилийн ойн арга хэмжээ болж өнгөрсөн.

#### 2019-2022 оны гол үзүүлэлтүүд:

Би энэ хэсгийг дэлгэрэнгүй танилцуулна. 4 гол тоо байгаа. 2019, 2020, 2021 он болон 2022 онд юу зорьж байгаа талаар. 2019 онд Говь ХК түүхэнд анх удаагаа 209.8 тэр бум төгрөгийн борлуулалт хийж, түүхэндээ анх удаагаа 1.5 сая бүтээгдэхүүн борлуулсан. Гэтэл 2020 оноос ковид гараад 1.5 маань 2 дахин буураад 700,000 бүтээгдэхүүн болсон. 2021 онд ковидын нөлөө арай багасаад энэ тоо маань 900,000 болсон. Энэ онд 2019 оныхоо түвшинд очиж чадахгүй ч гэсэн 1 сая ширхэг бүтээгдэхүүн борлуулахыг зорин ажиллаж байна. 2019 онд Говь ХК Гоёо ХХК-ийг худалдаж аваад Монголынхоо төдийгүй дэлхийн номер 1 ноолуурын компани болох зорилт тавиад дэлхийд онлайнаар бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн байгаа, 2019 оны 7 сараас. Монголынхоо болон дэлхийн маркетингд 12.9 тэрбум төгрөг зарцуулаад 2.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. 2020, 2021 оноос үсрэнгүй өсөлт хийх гээд байж байтал ковидын шалтгаанаас болоод ийм алдагдалтай гарсан. Компани 2021 онд 37.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Энэ нь тайлант үеийн эцэс дэх өөрийн хөрөнгийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байна. Өнгөрсөн жил бид хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж байхдаа 2021 ондоо ковидын нөлөө арай эрт дуусах байх гэсэн төсөөлөлтэй байсан, харамсалтай нь тэгээгүй. Яг өнгөрсөн оны едийд Монгол улс хөл хориотой байсан. 2022 онд бид үсрэнгүй байхаар дахиж бодож төлөвлөж байгаа. Та бүхэн мэдэж байгаа 2019 оны 1.5 сая ширхэг бүтээгдэхүүний борлуулалтын 1 сая ширхгийг бид Монголдоо борлуулсан. 1 сая ширхгийг борлуулахдаа бид Монголчуудад 500,000 мянган бүтээгдэхүүн, Монголд ирж байгаа жуулчдад 500,000 бүтээгдэхүүн борлуулсан. Энэ 500,000 мянган бүтээгдэхүүнийг Монголын 180,000 худалдан авагчдад борлуулсан. Монголд ирсэн жуулчдын 180,000 хүнд бүтээгдэхүүнийг борлуулсан. 2019 оны 7 сарын 9-нд Солонгосын 2 дахь авиа компани Монгол руу нисэж эхлээд Монгол Солонгосын хооронд билетийн үнэ 30% хямдарч 2020 оноос Монголд ирэх жуулчдын тоо огцом өссөн. Ер нь Монгол улс Солонгос улсаас 1 сая жуулчин авахаар зорьж ажиллаж байгаа. 1 сая жуулчин ирвэл бид тэд нарт 1-1.5 сая ширхэг бүтээгдэхүүн ч борлуулах боломж байгаа. 2019 онд 180,000 худалдан авалт хийсний 90,000 орчим нь Солонгос хүмүүс байсан.



### **Түүхий эдээс бэлэн бүтээгдэхүүн:**

Өнгөрсөн хугацаанд Говь ХК юу болсон тухай ярья. Би өөрөө 2008 онд Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал болсон. Тухайн үед 1 кг ноолуур 32,000 төгрөг байсан. Бид үүгээр бүтээгдэхүүн хийгээд 97,000 төгрөг болгон борлуулж чаддаг байсан. Тэр үед Говь ХК-ийн хувьцааны үнэлгээ 18.3 тэрбум төгрөг байсан. 2019 онд ковидын өмнө 1 кг ноолуур 126,000 төгрөг болоод үүнээс 3.9 дахин өсөлттэй болсон. Өнөөдөр бид 1 кг ноолуураас бүтээгдэхүүн хийгээд 284,000 төгрөгийн борлуулалт хийж чаддаг компани. Бүтээгдэхүүний түүхий эдийн үнэ ч өссөн, бид борлуулж байгаа бүтээгдэхүүнийхээ үнийг ч өсгөөд явж чадаж байгаа. Хэрэв энэ мах юм уу гурил байдаг байсан бол төр засгаас хязгаар тавиад ингэж өсгөж болохгүй гэх байсан байх. Гэтэл ноолууран бүтээгдэхүүн бол хүн амын мах гурил шиг зайлшгүй хэрэглээний бүтээгдэхүүн бас биш юм л даа. Та бүхэнд мэдээлэл болгох үүднээс хэлэхэд 2020 онд Говь ХК Хөгжлийн банкнаас зээл аваад 1 кг ноолуурыг 61,000 төгрөгөөр худалдаж авч чадсан. Зах зээл дээр бүх хил хаалттай байсан. Бид 40 тэрбум төгрөгөөр 604 тонн ноолуурыг 61,000 төгрөгөөр худалдаж авч чадсан. Энэ жил 1 кг ноолуурын үнэ 160,000 төгрөг байгаа. Энэ бол менежментийн хувьд зөв шийдвэр болсон гэж итгэж байгаа. Та бүхэнд сонирхуулаад ярья. Манай бүтээгдэхүүний нэр төрөл бол нэхмэл бүтээгдэхүүн, бээлийнээс оймс, цамц, даашинз гээд сүлжмэл бүтээгдэхүүн, бид дэлхийд номер 1 болж чадсан пальто оролцоод оёмол бүтээгдэхүүн гэсэн 3 өөр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Аль бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас хамаараад нэг бүтээгдэхүүнд орж байгаа ноолуурын граммын хэмжээ өөр байдаг. Бид 1 тонн ноолуураас 1,800-1,950 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж чаддаг. 2007 онд 1 тонн ноолуур 32 сая төгрөг байсан. 2019 онд 126 сая төгрөг байсан бол энэ жил 160 сая төгрөгийн үнэтэй байгаа гэсэн үг. Бид 2022 онд 167 сая төгрөгөөр нэг тонн ноолуур аваад үүнийг дотоод, экспорт, онлайн гэсэн 3 төрлийн худалдаагаар борлуулаад 404 сая төгрөг болгож нэмүү өртөг үүсгэж борлуулж чаддаг болсон байгаа.

### **Онлайн зах зээл:**

2019 оноос хийж байгаа онлайн зах зээлийн талаар 2021 онд юу байсан талаар танилцуулъя. Дэлхийн хамгийн том эдийн засаг буюу Америкийн зах зээл дээр онлайн худалдаа 2019 онд эхэлсэн. Өнгөрсөн жил бид 49,500 ширхэг бүтээгдэхүүн борлуулаад 9.4 тэрбум, дэлхийн номер 2 эдийн засаг Хятадын зах зээл дээр бас ковидоос болоод өнөөдөр ч гэсэн манай склад хаалттай байгаа. Нийт 16,200 ширхэг бүтээгдэхүүн борлуулаад 4.4 тэрбум, Европын зах зээлд бараг 100,000 ширхэг бүтээгдэхүүн борлуулаад 27.1 тэрбум төгрөг. Нийтдээ 165,300 ширхэг бүтээгдэхүүний борлуулалт хийгээд 40.9 тэрбум олсон. 2019 онд 9.4 тэрбум байсантайгаа харьцуулахад 4 дахин өсөлт үзүүлсэн байгаа. Бид онлайн худалдааг дэлхийд хийхдээ өнгөрсөн жил Говь ХК-ийн дэлхийн зах зээлд гарах концепцийг боловсруулахад хамтарч ажилласан дэлхийн номер 1 маркетингийн компани болох Ogilvy-тэй хамтарч ажилласан. Үйлчилгээ үзүүлэхийн төлөө дэлхийн номер 1 харилцагчийн үйлчилгээний платформ Salesforce гээд Америкийн компанитай хамтардаг. Европт номер 1 зах зээлийн талбар (marketplace) буюу манай бүтээгдэхүүнийг Европын бүх худалдан авагчдад борлуулж чаддаг Zalando компанитай интеграци хийгээд борлуулалтаа хийгээд явж байгаа.

### **Онлайн борлуулалт:**

2019, 2020, 2021, 2022 онд бидний зорьж байгаа тооны талаар илэрхийлсэн байгаа. Бид 2019 онд онлайнгаар 9.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн, 2020 онд бол 31.6 тэрбум болж гурав гаруй дахин өсөлт хийж чадсан. 2021 онд ковид болон олон зүйлс шалтгаалсны улмаас огцом өсөлт



хийж чадаагүй. 2022 онд бид 2021 оноос 20 гаруй дахин өсөлт гаргахаар төлөвлөж ажиллаж байгаа. Бүтээгдэхүүний тоо ширхгийн хувьд энэ жил 2019 онтой харьцуулахад бид 10 дахин өсөлт гаргахаар зорин ажиллаж байна. Анх удаа бидний онлайн борлуулалт 99.3 тэрбум болж, 341,000 ширхэг бүтээгдэхүүн борлуулж дотоодынхоо борлуулалтаас манай онлайн борлуулалт анх удаа давах ийм зорилго тавин ажиллаж байгаа.

#### **Нэг харилцагчийг татах зардал:**

Онлайн худалдаа дээр дэлхийн номер 1 хайлтын engine Google-ийг ашигладаг. Анх Google-тэй хамтарч ажиллаж эхэлж байхад хэлж байсан брэндийн нэр хүнд өсөх тусам нэгж харилцагчийг олж авчирдаг зардал буурна гэдэг дээр бид ойлголцоод ажиллаж эхэлсэн. Говь-ийн нэг харилцагчийг татах зардал анх эхэлж байхад өндөр байсан, нэг хэсэг өссөн, одоо нэг харилцагчийг татах зардал бол 12 евро, 12 ам.доллар болж огцом бууруулж чадсан.

#### **Онлайн маркетингийн зардал:**

Европ болон хойд Америкийн зах зээл дээр нэг харилцагчийг татах зардал 10 евро, 15 ам.доллар болж буурч байгааг илэрхийлсэн үзүүлэлт байгаа. 2021 онд бол бид ийм хүнд хэцүү байгаа ч гэсэн онлайн маркетингд 37 тэрбум төгрөг зарцуулж чадсан. Энэ жил бол 23.4 тэрбум төгрөг болгосон. Харилцагчийг татах зардал буурч байгаатай холбоотойгоор маркетингийн зардал бас буурч байгаа. Та бүхэн мэдэж байгаа 2020 оны сүүлээр Англи улс Европын холбооноос гарсан. 2020 онд Европын холбоон дотор Английн борлуулалт хоёрдугаарт эзэлдэг байсан. Англи улс Европын холбооноос гарсантай холбоотойгоор 2021 онд манай Английн борлуулалт буурсан. Тийм учир бид өнгөрсөн оны 8 сарын 1-ээс Английн зах зээлд компани байгуулаад үйл ажиллагаа эхлүүлэхээр ажиллаж байгаа. Герман бол манай номер 1 зах зээл байгаа. Европ+Английг бид хоёр дахь том зах зээлээ болгож хөгжүүлж чадна гэж харж байгаа.

#### **Говь ХК цаашид:**

Говь ХК цаашид яаж хөгжих вэ, ковидын 2 жил бол өсөлт хийх хөгжих боломжоо алдсан. Энэ оноос эхлээд хойшид яаж хөгжих тухайгаа та бүхэнд танилцуулъя. Монголчуудын амьдралд ноолууран бүтээгдэхүүн маш ойр байдаг. Европ, Америк, Хятадад бас тийм биш. Бид дэлхийн номер 1 ноолуурын компани болохын тулд бүтээгдэхүүнээ борлуулж байгаа зах зээл дээрээ "Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт байлгах" ийм концепцийг дэвшүүлээд үүнийг хэрэгжүүлээд явж байгаа. Эрхэм зорилго маань "Загварлаг, чанартай, нийцэмжид үнэтэй ноолууран хувцсыг дэлхийд таниулж, хүн бүрийг ноолуураар гоёно" гэсэн уриатай. Эцэст нь 1 "Ноолууран хувцсыг хүн бүрд" хүргэх зорилготой манай хамт олон ажиллаж байгаа. Би дотроо зорьж байгаа манай хамт олон зорьж байгаа энэ зорилтыг хувьцаа эзэмшигч та бүхэнтэйгээ хуваалцъя гэж бодож байгаа. Бид 2019 онд 1.5 сая бүтээгдэхүүн борлуулаад 79 сая ам.долларын борлуулалт хийж чадсан. Үүний задаргааг аваад үзвэл дотооддоо 1 сая бүтээгдэхүүн борлуулсан, экспортоор 500,000 бүтээгдэхүүн борлуулсан, онлайнаар 34,000 бүтээгдэхүүн борлуулсан. 1 сая бүтээгдэхүүний задаргааг үзвэл 500,000 бүтээгдэхүүнийг манай дотоодын 180,000 хүн худалдаж авсан. Нэг хүн ойролцоогоор 2,6-2,7 ширхэг бүтээгдэхүүн гэсэн үг. Монголд ирсэн 300,000-400,000 жуулчдын 180,000 нь 500,000 ширхэг бүтээгдэхүүн худалдаж авсан. Дэлхийн 3 том зах зээл байгаа. Америк өөрөө дэлхийн номер 1 эдийн засаг. Дэлхийн эдийн засгийн 24.8%-ийг эзэлдэг, дэлхийн хүн амын 4.2%-ийг эзэлдэг зах зээл дээр 2019 онд 6,000 бүтээгдэхүүн зарсныгаа бид 2030 онд 1.5 сая бүтээгдэхүүн болгож чадна гэж зорьж байгаа. Монголынхоо бүтээгдэхүүний

борлуулалтын логикоос хараад ч тэр Европын холбоо бол бидний хувьд хамгийн том зах зээл. 2030 онд бид 5 сая бүтээгдэхүүн борлуулах зорилго тавьж байгаа. Европын холбоо дээр нэмэх нь Англи улс. Монголдоо бол бид 2019 онд 1 сая бүтээгдэхүүн борлуулсан бол 2030 онд 2 сая бүтээгдэхүүн борлуулах зорилт тавина. Хятадын зах зээл дээр Америктай адилхан 1.5 сая бүтээгдэхүүн. Нийтдээ бид дэлхийн нийт эдийн засгийн 63.4%-тай тэнцэх эдийн засаг дээр 10 сая бүтээгдэхүүн борлуулаад, уул уурхайн бус тэрбум ам.долларын компани болох зорилго тавьж байгаа. Үүний төлөө Говь ХК хэчнээн ажилтантай ямар компани болох талаар дараагийн хуудсанд гарна. Өнөөдрийн бид нарын суурилагдсан хүчин чадал 2.3 сая ширхэг бүтээгдэхүүн байгаа. Би өөрөө Говь ХК-ийн захирал болсон жил Говь 400,000 буюу 0.4 сая ширхэг бүтээгдэхүүн борлуулаад нийт 224 тонн ноолуур худалдаж авдаг компани байсан. Энэ нь 2019 онд бол 750 болсон. Гэтэл манай суурилагдсан хүчин чадал бол 1,150 байгаа. Бид Монголынхоо ноолуурын 50% буюу 5,000 тонн ноолуур худалдаж аваад, 95,000 малчин өрхийн жилд үйлдвэрлэж байгаа ноолуур худалдаж авах зорилт байгаа. Энэ үед бол одоо байгаа 1,600 ажилчдын тоо 10,000 болно. Нэмж бид 8,400 ажилтан авна. Улаанбаатар хотын түгжрэлийн асуудал, нэмээд хотын өртөг зардал, хотод ажилчдаа орон сууцтай болгох боломж энэ бүхнийг бодолцохоор Улаанбаатарт ойрхон бүс нутагт сүлжмэлийн үйлдвэр байгуулах замаар 10,000 ажилтантай тэрбум ам.долларын борлуулалттай, дэлхийн номер 1 ноолуурын компани болох зорилго зорилт тавьж байгаа. Анхаарал хандуулсанд баярлалаа. Дахиад асуулт хариултын цаг байгаа. Тэр үеэр та бүхний асуултад хариулах болно.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Ц.Баатарсайхан захиралд баярлалаа. Өнгөрсөн жилийн үйл ажиллагааны гол үр дүнгүүд, цаашид хэрэгжүүлэх гэж байгаа үйл ажиллагаа, алсын хараагаа та бүхэнд танилцууллаа. Одоо ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

#### **4.2 ТУЗ-өөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах**

*ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.*

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Манай энэ жилийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитораар Кэй Пи Эм Жи Аудит ХХК ажилласан. Хөндлөнгийн үнэлгээ орсон, бүх зүйл зүй ёсоороо тайлагнагдсан байгаа гэсэн баталгааг тус компаниас авч болно гэж би бодож байна. ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя. "Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөсөн зорилго зорилтуудаа биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн дайчлан ажилласан" гэсэн дүгнэлтийг оруулж байгаа. Одоо ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгээ-г урьж байна. Та бүхэнд компанийн хувьцаа, компанийн зах зээлийн үнэлгээний талаар мөн ногдол ашгийн талаарх мэдээллийг хүргэнэ. Хувьцаанд хөрөнгө оруулсан хүмүүсийн хувьд бол компанийн зах зээлийн үнэлгээ өсөх өөрөө их чухал байдаг. Нөгөө талдаа хувьцааны ханш бас өсөлттэй байх их чухал байдаг.



#### 4.3 Хувьцааны ханш, ногдол ашгийн талаар танилцуулах

*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.*

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Та бүхэнд би Говь ХК-ийнхаа хувьцааны арилжааны талаарх мэдээллийг танилцуулъя. Сүүлийн 3 жилийн хувьцааны арилжааны ханш харагдаж байна. Саарал хэсэгт 2021 оны ханшийн мэдээлэл байна. Голлох үзүүлэлтүүдийг танилцуулбал:

- 2021 оны хувьд нэгж хувьцааны дундаж үнэ 270.67 төгрөг байсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 31.5%-ийн өсөлттэй. Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд өдөрт дунджаар 81,860 ширхэг хувьцаа арилжаалагдаж байсан байна, 2020 онтой харьцуулахад 5.3 дахин өссөн үзүүлэлттэй. Арилжааны үнийн дүнгийн хувьд өдөрт дунджаар 22,5 сая төгрөгийн арилжаа хийгдэж байсан байна, 2020 онтой харьцуулахад 7.1 дахин өссөн үзүүлэлттэй байна. Компанийн зах зээлийн үнэлгээ 2021 онд 254,035,834,500 төгрөг болж өмнөх оноос 69.2%-р өссөн үр дүнтэйгээр 2021 оныг хаасан байна.
- Дараагийн слайд дээр 2021 оны хувьцааны арилжааг графикаар харуулж байна. Улбар шар буюу баганан мэдээллүүд нь өдөрт арилжаалагдсан хувьцааны тоо ширхгийн мэдээлэл байгаа, хэвтээ тэнхлэгт ногоон график нь хувьцааны хаалтын нэгжийн үнийг илэрхийлсэн байна. Тус графикаас харвал манай компанийн хувьцаа оны эхний хагастаа нэлээн тогтвортой байсан бол оны сүүлийн хагас руугаа нэлээд өсөлттэй болсныг та бүхэн харж болж байна. Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд 8 дугаар сарын 25-ны өдөр хамгийн их арилжаа хийгдсэн. Энэ нь нэг өдөр 4,338,588 ширхэг хувьцаа арилжаалагдсан байна. Хамгийн өндөр хаалтын ханштай байсан өдөр бол 9 дүгээр сарын 10-ны өдөр 393.62 төгрөгөөр хувьцааны ханш хаагдаж байсан байна. Оны эхэндээ нэгж хувьцаа 193 төгрөгийн ханштай байсан бол оны сүүлээр 325.64 төгрөг болж нэмэгдсэн байгаа.
- Та бүхэнд Гэрэлмаа дарга маань сая танилцууллаа. Хувьцаа эзэмшигч хүний хувьд бол компанийн хувьцааг эзэмшсэнээр 2 төрлийн аргаар өгөөжийг хүртэх боломжтой байдаг. Эхний арга бол мэдээж ногдол ашиг авах хэлбэрээр өгөөжөө хүртэж болно. Дараагийн арга хэлбэр бол компанийн зах зээлийн ханш өсөхийн хэрээр та бүхний эзэмшиж байгаа хувьцааны буюу хөрөнгийнх нь өгөөж хэмжээ нь тэр чигээрээ нэмэгдэж байдаг. Энэхүү график дээр бол 2007 оноос 2021 он хүртэлх нэгж хувьцааны хаалтын ханшийг түүхэн мэдээллээр харуулсан байна. 2007 онд Говь ХК маань хувьчлагдсан. 2008 онд Баатарсайхан захирал гүйцэтгэх захирлаар томилогдон өдийг хүртэл тогтвортой үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн тэлсээр байна. Ингээд харьцуулаад харвал хувьцааны ханш маань 2008 онтой харьцуулахад 2021 онд хувьцааны нэгж ханш 14.8 дахин өссөн байна.

#### **Ногдол ашиг:**

Та бүхэнд ногдол ашгийн мэдээллийг хүргэе. Говь ХК-ийн ТУЗ-өөс 2018 онд ногдол ашгийн журмаа боловсруулсан байдаг. Энэхүү журмын 2-р бүлэгт нь ногдол ашгийн бодлогоо тодорхойлсон байдаг. Энэхүү бодлого дээр ямар нөхцөлийг хангасан тохиолдолд ногдол ашиг олгох вэ гэдгийг мөн зааж өгсөн байгаа. 2.3-р заалт дээр "Компани, компанийн тухай хуулийн 47-р зүйл, компанийн дүрмийн 8.12-т заасан ногдол ашиг хуваарилах нөхцөлийг хангасан тохиолдолд ногдол ашиг хуваарилна" гэж заасан байгаа. Тус нөхцөлийг танилцуулбал, "Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх" гэсэн үндсэн шаардлага нөхцөл байдаг.



Энэхүү ногдол ашгийнхаа бодлогын хүрээнд ТУЗ хуралдан 2022 оны 2 дугаар сарын 14-ний хурлаар 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг олгох эсэх тухай хэлэлцэн гаргасан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя. "2021 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар" шийдвэрлэсэн байгаа. Тус шийдвэрийг хугацаанд нь Монголын Хөрөнгийн Бирж болон компанийнхаа цахим хуудсаар дамжуулан та бүхэнд мэдээлсэн. Өнөөдрийн хурал дээр албан ёсоор дахин мэдээлэл хүргэж байна. Баярлалаа.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** М.Сэлэнгэ-д баярлалаа. Хурлын дараагийн асуудалдаа орьё. ТУЗ юу хийдэг вэ, ажлаа хэрхэн хийсэн талаарх тайланг та бүхэнд хүргэе.

#### **4.4 ТУЗ-ийн 2021 оны ажлын тайланг танилцуулах**

*ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.*

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаат компанийн хувьд бол хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж ажилладаг хүмүүс байдаг. Бидний чиг үүргийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг дээдлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, олон нийттэй тогтоох харилцаа холбоо, нөгөө талдаа бас мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах гэсэн ийм 4 чиг үүргийн хүрээнд ТУЗ үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнийг хэрэгжүүлэхдээ бид 3 чиглэлийн үйл ажиллагааг чухал гэж хардаг. Компанийн ирээдүйн хөгжил, стратегийн төлөвлөгөөтэй холбоотой шийдвэрүүдийг гаргах, хоёрт үйл ажиллагаанд хяналтаа тавих, санхүү тайлагнал дээр хяналтын функцуудыг хэрэгжүүлэх, нөгөө талдаа хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын багийн хамтын ажиллагааг хангаж, мэдээлэл өөрөө тасралтгүй явах, аль аль тал нь бүрэн дүүрэн мэдээлэлтэй ажиллагааг хангах чиглэлээр үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг байгаа. Нийт 780,112,500 ширхэг хувьцаа байгаа. Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 21,616 хүн байна. Бүтцээр нь хараад үзвэл Таван Богд Трейд ХХК 50.25%, Хидэ Интер ХХК 34.00%-ийг тус тус эзэмшиж байна. Үлдэж байгаа 15.75% нь манай жижиг хувьцаа эзэмшигч буюу та бүхэн энд сууж байна. Төлөөлөн удирдах зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй. 5 гишүүн хараат бус нарийн мэргэжлийн мэдлэгтэй хүмүүс байгаа, ердийн 4 гишүүнтэй. Бид өдөр тутмын байнгын үйл ажиллагаагаа явуулахдаа ТУЗ дэргэдээ 3 хороогоор үйл ажиллагаагаа явуулдаг. Эхний хороо бол эрсдэл аудитын хороо байгаа. Эрсдэлээ удирдах, хяналтаа тавих чиг үүрэгтэй хороо. Нөгөө хороо маань цалин урамшууллын хороо, гүйцэтгэх удирдлагын багийн авч байгаа ажлын гүйцэтгэлийг гүйцэтгэх захирлыг зүгээс үнэлсэн тайлантай танилцаж, бизнес төлөвлөгөөний зорилго, зорилтууд биелж байгаа эсэх, дарга нар маань үндсэн үүрэгт ажлаа ямархуу түвшинд гүйцэтгэж байгааг хянах зорилготой. Мөн байгууллагын зардлын дийлэнх хувь нь цалингийн зардал байдаг учир үүнтэй холбоотой мэдээллийг авах хяналтын шаардлагууд тавигддаг. Сүүлийн нэр дэвшүүлэх хороо маань энэ байгууллагыг удирдаад аваад явж байгаа удирдлагын баг өөрөө ямархуу түвшинд бэлтгэгдэж байгаа, залгамж халааны бодлого байгаа эсэх, дарга нарт сургалтын хэрэгцээ юу байгаа, өнөөдрийн гүйцэтгэл ямархуу байгаа гэдэг чиглэлээр бид хамтарч ажиллаж хяналтаа тавьдаг байгаа. Ийм бүтэцтэй манай төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаагаа явуулдаг. Өнгөрсөн жил бид нийт 26 удаагийн хурал хийжээ үүнээс төлөвлөсөн хурлын тоо 6, ээлжит бус хурал 20 явсан байна. Түрүүний ярьсан чиг үүргийн хүрээнд бол нэлээдгүй олон шийдвэрүүдийг гаргалаа. Үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын хүрээнд 1 тогтоол баталсан, өнгөрсөн 2 жилийн хугацаанд дэлхий нийтээрээ эдийн засгийн агшилтыг хийсэн жилүүд



байсан учир хөрөнгө оруулалт, хөгжлийн чиглэлээр бид том зүйл төлөвлөөгүй. Компанийн дотоод үндсэн үйл ажиллагаатай холбоотой 19 тогтоол гарсан байна, санхүүжилттэй холбоотой 16 тогтоол, хүний нөөцтэй холбоотой 3 тогтоол гарсан байна. ТУЗ бүрэн эрхийнхээ хүрээнд энэ жил тус ажлуудыг хийсэн байна.

## 1. ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАН

### Бүрэлдэхүүн:

Эрсдэл, аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа

ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан

Эрсдэл аудитын хороо эрсдэлээ удирддаг, хяналт тавьдаг чухал байнгын ажиллагаатай хороо байдаг. Нийт 5 удаа хуралдаж, 17 асуудлыг хэлэлцсэн, 7 төрлийн санал зөвлөмжийг удирдлагын баг руу шилжүүлж ажилласан.

### Онцлох ажил:

- Компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- Дотоод хяналтын бодлогын баримт бичиг болон Хөндлөнгийн аудит томилох тухай журмыг тус тус шинээр боловсруулан баталсан. Журмууд байгаа ч гэсэн амьдрал өөрөө их урагшаа явж байгаа шинэ мэдлэг, шинэ аргууд, үйлдвэр, манай Говь ХК өөрөө тэр чигээрээ цахим шилжилтийг хийж байгаа гэдгийг та бүхэн анзаарч байгаа байх. Үүнийгээ дагаад манай бүх бодлогын баримт бичигт жил бүр тодорхой хэмжээний сайжруулалт хийгдэж байгаа, үүний нэг тод жишээ энд харагдаж байна.
- Эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, хагас жилийн болон жилийн ажлын тайлантай цаг тухай бүрд танилцаж удирдамжаар ханган ажилласан.
- Хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, санал өгч оролцсон бөгөөд ТУЗ-ийн хурлаар сонгон шалгаруулав. Өөрөөр хэлбэл гарч ирж байгаа мэдээ тайлан нь бодитой, амьдрал дээр ийм байгаа гэдэг нотолгоог гаргаж өгдөг чухал хөндлөнгийн үнэлгээ хийдэг аудитыг хэлдэг. Үүнийг бид нэлээн нарийн шалгуур үзүүлэлтүүдээр хамтаараа шийдвэр гаргаж сонгодог байгаа.
- Эрсдэл аудитын хорооны үндсэн үйл ажиллагаанаас гадна хамаарал бүхий этгээдүүдийн хооронд, ашиг сонирхол нэгтэй хүмүүсийн хооронд хийгдэж байгаа худалдан авалт санхүүжилтийн талаар мэдээлэл хүргэе. 2021 онд хийсэн холбоотой талын гүйлгээ Таван Богд Групп. Говь өөрөө Таван Богд Группийн охин компани та бүгд мэдэж байгаа. Санхүүжилтийн нийт зардал 25,474,286,000 байсан байна. Үүнээс холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал 2.3 тэрбум төгрөг болсон. Нийт санхүүжилтийн зардлын 9%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийг хүү 7.3% байгаа. Энэ нь санхүүгийн харьцааны тусгай нөхцөлүүд болон барьцаа нэхдэггүй ийм онцлог санхүүжилтийн эх үүсвэр байдаг. Дараагийнх худалдан авалттай холбоотой. 2021 онд хийсэн ерөнхий худалдан авалт дээр Таван Богд Группээс авсан худалдан авалт. Нийт худалдан авалтын 5.5%-ийг холбоотой талаас Говь ХК хийжээ. Дотоодын худалдан



авалтын 13.6%-ийг дотроосоо Таван Богд Группийн компаниудаас авсан байна. Холбоотой талаас авсан худалдан авалтын нийт дүн 454.4 сая төгрөг буюу нийт худалдан авалтын 5.5%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан худалдан авалт нь зах зээлийн үнэлгээгээр хийгдсэн гэдгийг манай хөндлөнгийн аудитор компани өөрөө баталгаажуулж өгөх болно.

## 2. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТАЙЛАН

### Бүрэлдэхүүн:

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр  
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа  
ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайхан

Хуралдсан тоо: 2 удаа

Хурлын үр дүн: 8 асуудлыг хэлэлцэн 11 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан.

### Онцлох ажил:

- Менежмент багийн жилийн болон хагас жилийн тайлан, тус тайланд гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцаж үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжийг өгөв.
- Менежмент багийн жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав.
- 2021 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцэв.
- Компанийн засаглалын өөрийн үнэлгээг гүйцэтгэж Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллалаа.

## 3. ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ТАЙЛАН

### Бүрэлдэхүүн:

Цалин урамшууллын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа  
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ  
ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг

Хуралдсан тоо: 2 удаа

Хурлын үр дүн: 8 асуудлыг хэлэлцэж, 10 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан.

### Онцлох ажил:

- Компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, компанийн байгууллагын соёлын судалгааны ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмж өгсөн.
- Хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2022 оны цалин урамшууллын төсвийг батлав.

### Засаглалын өөрийн үнэлгээ:

Бид тус үнэлгээг 5 дахь жилдээ хийж байна. Энэ нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт манай засаглал өөрөө ямархуу түвшинд байгааг олоод харах боломжийг олгодог чухал судалгаа

өөрийн үнэлгээ байдаг. Сүүлийн 3 жилийн үр дүнг та бүхэнд танилцуулъя. Та бүхний хурлын материал дээр орсон байгаа дэлгэрэнгүй байдлаар жилийн тайлангаас танилцаарай. 2021 оны байдлаар Говь ХК-ийн засаглал 92.2%-тайгаар үнэлэгдсэн. Сайн засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн түвшинд байна гэсэн үнэлгээ хийгдэж байгаа. Үүгээрээ бид нэлээн бахархдаг ийм хэмжүүр ажиллаад эхэлнэ гэдэг нь цаашид хийх ажлуудаа нэлээн тодорхой болгоход нөлөө үзүүлдэг байгаа. Сайн зүйлүүд байгаа ч гэсэн цаашид анхаарлаа хандуулж ажлаа сайжруулах хөгжүүлэх чиглэлүүдээ бид гаргаж ирдэг. Энэ бол дандаа судалгаа нь дээр хийгдэж байгаа. 2021 онд засаглалын үнэлгээний үр дүнгээс энэ жилийн ажлын төлөвлөгөө рүү гээ оруулсан гол ажлуудыг та бүхэнд танилцуулъя.

#### **Цаашид гүйцэтгэх ажил:**

##### ***Мэдээллийн ил тод нээлттэй байдал.***

- Та бүхний оруулсан хөрөнгө зүй зохистой ашиглагдаж байгаа эсэх, энэ нь компанийн хөгжилд хувь нэмэр оруулж байгаа эсэх, зах зээлийн үнэлгээ өсөх эсэх, ногдол ашиг, нэгж хувьцааны үнэ өөрөө ямархуу төлөвтэй байх уу гэдэг нь бид бүгдийн үйл ажиллагаанаас маш их хамаарна. Үүний талаар та бүхэн маш их мэдээлэлтэй байх ёстой болдог. Үүний хүрээнд бид мэдээллээ ил тод нээлттэй байлгахын тулд олон улсын сайн туршлагыг тасралтгүй судалж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр илүү нарийн үйл ажиллагааг явуулъя энэ дотроо гадаад хөрөнгө оруулагч нартаа зориулаад компанийн веб хуудас дээр байгаа засаглалын мэдээллийг англи хэл дээр гаргадаг болох ажил төлөвлөсөн.
- Мэдээллийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг ханган мэдээллийн агуулга, цар хүрээгээ улам бүр сайжруулах. Бид дотроо цахимжиж байна, борлуулалт өөрөө бас цахим болж байна, амьдрал өөрөө дийлэнхдээ дандаа цахим талбар дээр явж байгаа учир өгч байгаа мэдээллийн агуулга, нийцтэй байдал, хэрэглэхэд хялбар байх талаас нэлээн сайн нарийн ажиллагаануудыг хийх шаардлагатай гэж бодож байгаа.
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг боловсронгуй болгох.
- Хувьцаа эзэмшигчидтэй холбогдох цахим харилцааны боломжит хувилбаруудыг улам сайжруулах.

##### ***Дотоод хяналт үйл ажиллагааны чиглэл.***

- Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна. Бүх зүйл цахим руу орсон. Аюулгүй байдлаа сайжруулах эргэж бодох зүйлшгүй шаардлагууд байгаа.
- Эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг шинэчлэх шаардлага байна. Ковид гээд том цочрол өгсөн. Одоо бол тогтворгүй байдлууд их байгаа учир энэ нь эргээд манай эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна. Инфляц нэлээн өндөр болж байна, эргэлт нэлээн саарах байдалтай үүнийг дагаад бодлого өөрчлөгдөхгүй бол сүүлийн 2 жил энэ чиглэлээр ажлууд хийгдээгүй байгаа.
- Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс суртахуунгүй үйлдлүүдийн талаар ТУЗ-тэй шууд холбогдож мэдээлэл өгөх тухай заалтыг ёс зүйн дүрэмд нарийвчлан тусгах, хэрэгжилтийг ханган ажиллах.



Анхаарал тавьсанд баярлалаа. ТУЗ-ийн 2021 оны тайлан та бүхэнд хүргэгдлээ. Асуулт хариултын хэсэг эхэлж байгаа. 20 минут төлөвлөсөн байгаа. Та бүхэн чөлөөтэй асуултаа асууна уу.

## 5. АСУУЛТ ХАРИУЛТ

/Нийт 20 минут/

**АСУУЛТ 1. Хувьцаа эзэмшигч Ганболд:** Энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигч Ганболд байна. Хоёр асуулт байна. 1-т хурлын материал дэлгэрэнгүй их сайн болсон байна, үүнийг бэлтгэсэн хүмүүст баярлалаа. Өнгөрсөн оны хурлыг цахимаар үзсэн. Тэр хурал дээр гүйцэтгэх захирлын хувьд 2022 оны нэг амлалт өгсөн. Ашгийн төлөвлөгөөг 46 тэрбум ногдол ашгийн тодорхой хувь. Мэдээж би ойлгож байна цар тахал, олон улсын мөргөлдөөнтэй асуудалтай нэлээн хүнд байх гэж бодож байна. Үүн дээр тайлбар авъя. 2-т нь төлөвлөгөө мэдээж ТУЗ-өөр орж батлагдаж байгаа байх. ТУЗ-ийн байр суурийг бас авмаар байна. Өрийн харьцааг харвал нийт хөрөнгийн дийлэнх нь өр байх шиг байна. Цаашид өрийг бууруулах энэ чиглэлийн ямар ажлууд байгаа вэ? Гүйцэтгэх удирдлагын баг олон улсын зах зээлд нэлээн идэвхтэй ажиллаж байх шиг байна. Баяр хүргэе, амжилт хүсье.

### **Хариулт:**

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** 2019 онд Говь ХК Гоёо ХХК-тай нэгдээд 2.3 сая бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийд гарах яг зорилттой яваад эхэлж байгаад эхний жилд нь 2020 онд ковид гарсан. Өнгөрсөн жил хурлыг хийж байхад ч гэсэн ковидыг ийм удаан үргэлжилнэ гэж ерөөсөө төсөөлөөгүй. Төсөөлөөгүй зүйлс сүүлийн үед бас хэтэрхий их байгаа. Гэхдээ үүний цаад хамгийн том шалтгаан юу гэхээр бид дотоодын зах зээлээс хэтэрхий хамааралтай компани байсанд гол асуудал оршиж байгаа. Учир нь 2019 оны нийт борлуулалтын маш бага хэсэг нь онлайнаар өөрсдөө шууд борлуулдаг. Дотоодын борлуулалт 1.5 сая ширхэг бүтээгдэхүүний 1 сая нь дотооддоо борлогддог. 500,000 нь бөөний үнээр зардаг. Бөөний үнээр зараад байгаа нь өнөөдөр онлайнаар болон Монголдоо зарж байгаа үнээс 2 дахин бага ашигтай. Учир нь манайхаас бөөнөөр худалдаж аваад цаашлаад жишээ нь Солонгосын нэг худалдан авагч байна. Манайхаас худалдаж аваад дотоодын home shopping зарахын тулд маркетингийн зардал бусад үйл ажиллагааны зардал гээд. Ер нь 2021 оны экспортод 340,000 ширхэг бүтээгдэхүүн борлуулаад 30 тэрбумын борлуулалт хийж байсан. Энэ жил бид 240,000 болгоод 100,000-р бууруулаад борлуулалтаа хэвээр хадгалж байгаа. Бөөний үнээр зардаг бүтээгдэхүүнийхээ ашгийг өсгөөд тоо ширхгийг бууруулаад байгаа гэсэн үг. Эцэстээ Говь зөвхөн дотооддоо эцсийн хэрэгчдэд өөрсдөө борлуулдаг, онлайнаар эцсийн хэрэглэгчдэд борлуулдаг. Сая миний илтгэсэн тайлан дээр байгаа өнгөрсөн жил бид ямар ч гэсэн Европын зах зээл дээр 200,000 харилцагчтай болж чадсан. Дэлхий дээр Говь ХК өрсөлдөгч байхгүй. Учир нь ноолууран оймс бээлийнээс пальто хүртэл борлуулалт хийж чаддаг ийм том цар хүрээтэй ажиллаж чадаж байгаа компани Говь-с өөр байхгүй. Гэхдээ бидэнд ямар бэрхшээл байна гэхээр энэ том зах зээл дээр өөрийгөө таниулахын тулд маркетингд маш их зардал шаардаж байгаа. Тийм учир 144 тэрбум орчим төгрөгийн борлуулалт хийгээд 40 тэрбум төгрөгийг маркетингийн зардал гаргана гэдэг бол маш хүнд байна л даа. Гэхдээ үүнийг хийхээс өөр сонголт байхгүй. Монгол улсын засгийн газрын их хурлын түвшинд юу гэж яригдаж байгаа гэхээр Монгол улсын уул уурхайн бус экспортыг хэрхэн хөгжүүлэх вэ үүний гол манлайлагч нь Говь ХК байх ёстой гэж бид бүхэн харж байгаа. Харамсалтай нь бидний зорилт мөрөөдөл биелээгүй. Би өөрөө Таван Богд Группийн ерөнхийлөгч хийдэг, 13,000 орчим ажилчид ажилладаг. Говь ХК-с бусад манай группийн бизнес бол маш сайн явж байгаа.



Говь-ийн бас менежмент рүү Таван Богд Группийн мундаг залуучуудыг сүүлийн үед нэлээн авчирч байгаа. Хойшид Таван Богд Группийн олон улсын нүүр царай, Монгол улсын нүүр царайг бол Говь-ийг байна гэж үзэж байгаа. Тийм учир хамгийн шилдэг боловсон хүчнээ Говь дээр ажиллуулахаар манай Таван Богд Групп дэмжиж ажиллаж байгаа. Банкнаас зээл авахад Таван Богд Группээс баталгаа гаргаж өгч дэмждэг. Говь ХК-ийн борлуулалт Монголын аялал жуулчлалтай маш холбоотой. Та бүхэн өнгөрсөн 7 хоногт харсан байх. Солонгосын 2 ч авиа компани 6,7,8 сард Монгол руу нисэхээр болж байгаа. Тэгэхээр Солонгосоос 5 авиа компани нисээд Монголд ирвэл, Солонгосын зах зээл дээр манай бүтээгдэхүүн номер 1 брэнд болж чадсан байдаг.

**АСУУЛТ 2. Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Нэг төгрөгт ногдох зардал хоёр жил дараалан өссөн. Түрүүн цалингийн зардал ихэнх зардал гэж байсан. Гэтэл нийт ажилчдын тоо чинь буурсан байна. Урт хугацаат өр төлбөр чинь өндөр байгаа юм байна. Урт хугацаат өр төлбөр бол компанид ашигтай л даа. Зардлыг яаж ингэж өндөр барьж явж байна? Хөндлөнгийн гишүүд товч хариулаад өгнө үү. Ийм их зардал гаргаж байж яаж ажиллах вэ?

**Хариулт:**

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Говь ХК 2024 он гэхэд ямар нэгэн зээлгүй компани болно гэж зорьж байгаа. Малчдаас түүхий эд худалдаж аваад эцсийн бүтээгдэхүүн болгоод бид 3 дахин нэмүү өртөг үүсгэж зарж чадаж байгаа. Та бүхэнд бас сая тайлбарлаж ярьсан. Би өөрөө 2008 онд гүйцэтгэх захирал болсон. 1 кг ноолуур 32,000 төгрөг байсан. Өнөөдөр 1 кг ноолуур 160,000 төгрөг байгаа.

**Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Би үүнийг асуугаагүй. Компанийн нэг төгрөгийн орлогод ногдол зардлын талаар асуусан. Ажилчдын чинь тоо буурсан цалин буурсан. Гэвч зардал чинь жил дараалан өндөр байна. Яагаад ийм өндөр байна?

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Би зардлыг өндөр байна гэж бодохгүй байна. 1,600 хүнтэйгээрээ бид 10,000 хүнтэй компани болохын төлөө зорьж ажиллаж байгаа учир ажилчдын тоог үүнээс бууруулах боломжгүй.

**Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Ийм их зардалтай цаашид яаж ажиллах вэ?

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Ковидын нөлөө алга болоход бид цаашид ашигтай компани болно.

**Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Ковидоор гэхдээ зардал буурч болно шд ээ.

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Ямар зардал буурах уу?

**Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Зах зээл сул зогссон үед ажилчдаа цөөлсөн юм чинь зардал буурна. Цахилгаан дулааны зардал гэх мэт.

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Ажилчид өнөөдөр зардал биш юм.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Чухал асуулт тавьж байгаад баярлалаа. Таны асуултад манай хараат бус гишүүн Жаргалмаа хариулна. Би нэг асуултад нь хариулья. ТУЗ-ийн зүгээс ямар байр суурьтай байна гээд. Төлөвлөгөөний талаар байнгын хяналттай ажилладаг. Цахим худалдаа руу орсон. Танигдах ёстой хөрөнгө оруулалт хийх ёстой. Зүгээр нэг 2 уулзсан хүнд танигдах дахин давтан тэр хүмүүстэй ойлгуулах, сонгуулийн үйл ажиллагааг та санаарай, яаж бид хүнийг сонгодог билээ. Яг тэрэн шиг бид олон улсын тавцан дээр Говь-ийн бүтээгдэхүүнийг таниулахын тулд тасралтгүй маш их хэмжээний мөнгө зарж байж бид олон улсын тавцан дээр гарч байгаа. Энэ нь өөрөө тоолуур гүйхтэй адилхан гэж би хэлье. Танигдалт сайн явбал яваандаа манай зардлууд



бүгд буугаад эхэлнэ. Ковидын 2 жил аль аль талдаа амаргүй байлаа. Гэхдээ бид их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн гэж ойлгоорой. Маркетингийн зардал их өндөртэй ажилласан.

**ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа:** Сайн байна уу. Та хараарай маркетингийн зардал гээд 2020 он нь 25 тэрбум, 2021 он нь 39 тэрбум байгаа.

**Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Би өөрөө ойлголтоо олж авах гээд ингэж байгаа юм шүү.

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Тэгэлгүй яах вэ, ойлгож байна. Нэгж харилцагчид ногдож байгаа зардал буурч байгаа, нийт зардал яваандаа бол буурна гэж хэлж байгаа шд ээ. Та асуултаа ойлгомжтой тавина уу. 2021, 2020 оноо ялгаж харах хэрэгтэй.

**АСУУЛТ 3. Хувьцаа эзэмшигч Оюун:** Хурлын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байна. Говь ХК-ийг дэмжиж явдаг. Цөөхөн хувьцаатай ч гэсэн үүнийгээ зарахгүй дэмжээд явдаг хувьцаа эзэмшигч байна. Би хувьцаа эзэмшигчийн хувиар бүтээгдэхүүнийг нүдээрээ харж явдаг. Говь ХК загварын чиг хандлагаараа дэлхийд хаана явдаг вэ? Би харахад загварын хувьд төдийлөн таалагддаггүй. Эрэгтэй хүмүүсийн хувцаснууд харин таалагддаг. Дэлхийд номер 1 явдаг та бүхэн бас өөр чиглэлээр хардаг байх. Загварын чиг хандлагын хувьд хаана байгаа вэ? 2-т дэлхийн дулаарал явагдаж байна. Ноолуур цаашид яах вэ? 20-30 жилийн дараа манай Говь ХК ямар түвшинд очсон байх вэ? 3-т тэтгэврийн насны ахмад хувьцаа эзэмшигч бол нэлээд байгаа гэж бодож байна. Жилд нэг удаа ч гэсэн ахмад тэтгэврийн настнуудыг ямар нэгэн жижиг байдлаар ч гэсэн урамшуулал дэмжлэг олгох тийм бодлого байдаг уу? 4-т нь өнгөрсөн хурлуудаар хувьцаа эзэмшигч болгон нэлээн олон санал тавьсан. Эргээд энэ гаргасан санал шийдэгдсэн эсэх талаар хариуг ямар байдлаар өгдөг вэ? 3 удаа хуралд ороод би санал тавьж байсан эргэж үүнийхээ талаар ерөөсөө сонсоогүй. Хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналд хэрхэн хяналт тавиад эргэж мэдээлдэг вэ?

**Хариулт:**

**Борлуулалт, дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал Б.Болормаа:** Хувьцаа эзэмшигчдэдээ баярын мэнд хүргэе. Хүрэлцэн ирсэнд баярлалаа. 2009 оноос хойш бид олон улсын дизайнеруудтай хамтарч ажиллаж байгаа, Итали болон Английн дизайнерууд. 2021 онд Английн алдартай Мартин Паркер дизайнертай хамтран ажиллаж явж байна. Дэлхийн загварын чиг хандлагад бид нэлээн дээгүүр байр суурь эзэлж байгаа. Загварын трендийг бол мэдээж бид хоцрохгүй адилхан хөл нийлүүлэн алхаж байгаа. Жил бүр дизайнеруудаа олон улсын үзэсгэлэн үзүүлдэг, судалгаа сайн хийдэг. Тийм учир бид илүү загвараа сайн сайжруулаад явна гэж бодож байна. Баярлалаа.

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Говь ХК-ийн зорилго бол Монгол улсын бодлого зорилготой нийцэж байгаа. Монгол улс 10,000 тонн ноолуураасаа 1.5 их наяд төгрөгийн орлого олж байгаа. Монгол улс энэ 10,000 тонн ноолуурынхаа 1,000 тонныг эцсийн бүтээгдэхүүн хийж борлуулж чадаж байгаа. 2030 он гэхэд Говь үүний 5,000-ийг худалдаж аваад эцийн бүтээгдэхүүн болгоод дэлхийд 10 сая бүтээгдэхүүн үйлдвэрлээд борлуулах хэмжээний компани болно. Говь ХК-ийн хувь нэмэр үр дүнд ноолуурын салбараас олж байгаа 1.5 их наядыг 4.5 их наяд 5 их наяд болгох зорилго тавьж байгаа. Онлайн худалдаа байгаа учир энэ боломжийг бий болгож байна гэж манай хамт олон харж байгаа. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд дэлхийд танигдах ажлын эхлэлийг тавих, энэ их маркетингийн зардлыг гаргах ажил бол өөрөө амар байгаагүй. Хөгжлийн банктай холбоотой Говь-ийн талаар та бүхэн зөндөө яриа явж байгааг сонсож байгаа байх. Хөгжлийн банкны энэ зээлтэй холбоотойгоор Хөгжлийн банкнаас Монгол банкнаас шалгалт манай дээр



ирсэн. Манай зээл дээр нэг ч төгрөгийн зөрчил байгаагүй. Зээлийн хоцрогдол бол үүсээд явж байгаа. Гэхдээ үүнийг бол хүү торгуультай нь төлөөд ирэх он гэхэд Хөгжлийн банктэй ямар нэгэн зээлгүй компани болох зорилго тавиад ажиллаж байна.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** За, баярлалаа. Саяны хувьцаа эзэмшигч Оюун гуайн асуултад би хариулт өгье. Дулааралтай холбоотой асуудал явсан. Дулааралтай дэлхий нийтээрээ л тэмцэж байгаа. Өөрсдийнхөө зүгээс байгаль орчныг доройтуулахгүй нийгэм дээр тэгш байдлыг хангахын тулд БОНЗ-ын бодлого энэ жилээс хэрэгжээд эхэлнэ. Нөгөө талдаа бүтээгдэхүүний хувьд бол жилдээ хоёроос нэг градусын дулаарал явж байгаа. Манай бүтээгдэхүүн зун өмсөх боломжтой байдлаар тодорхой хэмжээгээр хийгдээд явж байгаа. Дараагийн таны чухал асуултад би бас хариулт өгье. Хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналыг хэлэлцдэг үү эргээд ямар байдлаар хариулт өгдөг вэ гэсэн байна. Бид хэлэлцдэг ТУЗ-ийн хурал дээр заавал яригддаг. Зарим саналуудыг аваад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа үндсэн үйл ажиллагаа руугаа оруулдаг. Энэ дээр харин эргэх холбоотой ажиллах, тусгайлсан санал өгсөн хүмүүстэйгээ эргэж холбогдох чиглэлд анхаарлаа хандуулъя. Баярлалаа. Тэтгэврийн хүмүүстэй холбоотой бол та бүхний оруулсан хөрөнгийг өсгөх үржүүлэх, компанийн зах зээлийн үнэлгээг өндөр байлгахад л гол анхаарлаа хандуулж байгаа. Настнуудаа харж үзээд бидний зардал бүр улам өндөр болоод саяных шиг асуултауд гарна. Эргээд энэ чинь компаниас л гарах зардал. Бид компанийн зах зээлийн үнэлгээг өсгөх, хувьцаагаа сайн арилжаатай өндөр ханштай байлгах тал дээр байдаг анхаарлаа хандуулъя. Болж өгвөл ашигтай ажиллаад та бүхэнд ногдол ашиг хүртээхэд чиглэнэ. 2022 онд бидний бодож төлөвлөж байгаагаа ажил явбал бид өсгөөд явах хүсэлтэй байна. Говь-ийн хөгжилд хүн бүр санаа зовж байгаа. Та бүхний оруулсан хөрөнгийг өгөөжийг аль болох өндөр байлгахад хичээж байгаа гэдгийг дахин хэлье.

**АСУУЛТ 4. Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Би Говь-ийн хувьцаа эзэмшигчийн хувиар борлуулалтын талаар асуумаар байна. Сая хэлсэн 180,000 хүнд зарж байна гэж байна. Хүн амынхаа 5%-д бүтээгдэхүүн үйлчилгээ хүргээд байна гэсэн үг. Үүний борлуулалтыг хэрхэн сайжруулж болох вэ 3 сая хүнд бүтээгдэхүүнээ яаж хүргэх вэ? Дотоодын борлуулалт сая он онуудыг харахад 2019 онд 60%, 2020,2021 онуудад мэдээж дотоодын борлуулалт багасаад онлайн гадаад борлуулалт сайжирч байгаа. Тэр бас жуулчидтай холбоотой байх. 2-т борлуулалтын бэлтгэл ажлуудыг хийхээс гадна одоо хил гааль, олон улсын байдал сайжрахад 500,000 жуулчид дунджаар орж ирэх үү тэ? Тэрний 500,000-с 180,000 жуулчдад бас бүтээгдэхүүнээ хүргэдэг гэж байна. Тэр бас 30% хүрэхгүй байна. Үүнийг бас яаж 100% болгож жуулчин болгонд бүтээгдэхүүн борлуулах вэ?

**Хариулт:**

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Өмнө нь Говь ХК жилд 3-4 удаа коллекци гаргадаг байсан дотоодод, одоо сар бүр коллекци гаргаж байгаа. Өнгөрсөн оны 11 сарын 3-нд хямдралтай худалдаа хийснээс хойш дотоодын зах зээл дээр хямдралтай худалдаа огт хийхгүй, бүтээгдэхүүнийхээ загварыг сайжруулаад сар бүр шинэ коллекци гаргах замаар дотоодын борлуулалтыг нэмэгдүүлэх дээр ажиллаж байгаа. Ер нь хойшид ковидын нөлөөний дараа Монголд жуулчид нэмэгдэх нь мэдээж гэж ойлгож байгаа. Энэ хүмүүст зориулсан олон улсын үзэсгэлэн, арга хэмжээ аялал жуулчлалын компаниудтай хамтарч ажиллах дээр бол бид бүрэн дүүрэн ажиллаж байгаа. Өнгөрсөн оны 9 сараас дотоодын онлайн худалдааг бас эхлүүлсэн байгаа. Ковидын үед дэлгүүр хаагдсан байхад онлайн худалдаа үргэлжилж байсан. Тийм учир



онлайн бол сарын 50 сая төгрөгийн борлуулалттай түвшинд ирсэн байгаа. Үүнийг хариуцаж 5 хүн ажилладаг. Дотоодынхоо дижитал маркетинг дээр илүү анхаарч байгаа. Жуулчид нь нэмэгдэнэ, Монголчууд жилд 3-4 удаа коллекци гаргадаг байсан бол сар бүр цөөхөн нэр төрлөөр коллекци гаргаад явж байгаа, дотоодын борлуулалтыг нэмэгдүүлэх боломжтой гэж харж байгаа.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Цаг дуусаж байна. Сүүлийн асуултаа аваад хаая. Та бүхэн асуух гэж байсан асуултаа тэмдэглээд бидэнд өгөөрэй. Манай ТУЗ-ийн ажлын алба бидний зүгээс хариулт өгөөд явъя. Ямар нэгэн байдлаар холбогдоод хариулт өгье. Сэлэнгэ цаас тараагаад асуултуудыг авъя.

**АСУУЛТ 5. Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:** Сайн байна уу, жижиг хувьцаа эзэмшигч байна. Харин ч энэ хүндрэлтэй цаг хугацаанд Говь ХК маань дажгүй ажиллалаа гэж бодож байгаа. Та бүхэнд баяр хүргэе, цаашдын ажилд амжилт хүсье. Зардал гаргаж байж орлого орно. Орлого орж байж зарлага гарна гэсэн зарчим байдаг. Нийт борлуулалтын орлого болон зардалд цалингийн зардал хэдэн хувийг эзэлж байна вэ? Тэнцвэртэй харьцаа байна уу? 2-т үнийн бодлогын хувьд ковидын үед ч бай дотоодын борлуулалт нэмэгдсэн байна. Цаг үеийн байдлаасаа ч болж байгаа, манай Монголчууд бас өөрсдийн хэрэгцээ гэдгийг мэдэж байгаа учир ноолуур гэдгийг мэднэ шд ээ Монголчууд. Гэхдээ үнийн бодлогын уян хатан ялангуяа дотоодын борлуулалт ингэж нэмэгдэж байгаа учир үнийн бодлогоо яах вэ? Цаашдын ажилд амжилт хүсье.

#### **Хариулт:**

**Санхүү, удирдлага хариуцсан захирал Э.Тод-Од:** Өнөөдөр хүрэлцэн ирсэн та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сая их сонирхолтой асуулт асууж байна. Цалингийн зардлыг бид ямар түвшинд барьж ажилладаг вэ гэвэл бид бодлогоор хамгийн чухал 3-4 зардлуудаа гаргаад тэдгээр зардлуудыг хэрхэн бууруулах вэ, үйл ажиллагаагаа хэрхэн сайжруулах уу гэдэг дээр анхаарч ажилладаг. Үүний нэг бол яалт ч үгүй цалингийн зардал. Цалингийн зардал бол өнгөрсөн хугацаанд 20%-тай байсан. Үүнийг бол бид энэ жил улам бууруулаад 15%-с хэтрүүлэхгүй байх дээр анхаарч ажилласан байгаа. Бид төлөвлөгөөгөө ингэж гаргасан байгаа сая манай ТУЗ-ийн дарга хэлсэнчлэн урьдчилсан төлөвлөснөөс өөр болохгүй бол бид энэ төлөвлөгөөгөө биелүүлж чадна гэж үзэж байна. Баярлалаа.

**Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан:** Говь дэлхийн брэнд болохын төлөө олон улсад зарж байгаа үнэ дотоодод зарж байгаа үнэ яваандаа бол адилхан байх ёстой гэсэн зарчим баримталж байгаа. Дэлхийн брэндүүд тийм байдаг. Бид 12 сард үнээ өсгөсөн. Үүнээс хойш төгрөгийн ханш унасан. Ам.доллороор харахад манай үнэ бол боломжийн хямд байгаа. Гэхдээ борлуулалтаа хараад үнээ өөрчлөөд явна гэж харж байгаа. Эцэст нь нийт хувьцаа эзэмшигчдэдээ хэлэхэд би өөрөө хамгийн том хувьцаа эзэмшигч нь. Говь бол заавал хөгжинө. Та бүхэн дэлхийн онлайн худалдааны том компаниуд байдаг Amazon бусад компаниуд байдаг. Тэд эхэн үедээ ч гэсэн маш их зардал, хөгжүүлэлт дээр маш их маркетингийн зардал гаргадаг. Би бас залуучуудаа магтмаар байгаа. Манай онлайн худалдааг хариуцсан Мишээл гээд залуу байгаа, англи франц хэлтэй, Франц улсад боловсрол эзэмшсэн. Энэ захирал маань онлайн багийг удирдаад явж байна. Говь ХК-ийг ковидын үед 2,600 хүнээс 1,600 хүн болгоод 1,000 хүнээр орон тоо бууруулсандаа маш их харамсдаг. Гэтэл өнөөдөр Говь дампуурахгүй тэсэж үлдэхийн тулд үүнээс өөр сонголт байсангүй. Тэгсэн хэдий ч бид ковидын энэ хүнд үед ч гэсэн хүний амь эрсэдсэнгүй, ямар ч байсан давж

гараад ажиллаж байна. Хөрш Хятад улстай харьцуулахад Монгол улсын бараг бүх хүн халдвар аваад дархлаатай болчихсон. Би өөрөө Говь ХК-ийн гүйцэтгэх захирал 2008 онд болж байхад санадаг юм хажуу талд ийм дэлгүүр байгаагүй. Үйлдвэрийн хашаагаар ороод нэг давхарт дотоодын нэг дэлгүүр гэж байсан. Энэ склад байсан талбайг засаад дэлгүүр болгосноор манай борлуулалт маш их өссөн, сая ширхэг бүтээгдэхүүн дотооддоо борлуулдаг ийм хэмжээнд хөгжиж ирсэн. Ковид шиг ийм зүйл гараад бүтэн 2 жил хил хаагдаад ингэж зогсоно гэж бидний бизнес төлөвлөгөөнд ч байсангүй эрсдэлийн асуудал дээр ч байсангүй. Тооцоолоогүй байсан. Ковид дуусаж л таараа энэ бүхнийг бид даваад гарч таараа. Тэглээ гээд өнөөдөр Говь ХК-ийн хамт олон, миний бие гүйцэтгэх захирлын хувьд, ямар ч санхүүгийн байгууллага хэний ч өмнө хэлэхэд бидэнд хариуцлагагүй, ёс суртахуунгүй зүйл байхгүй. Авсан өр зээлээ бид төлж барагдуулна, удахгүй ашигтай ажиллана. Та бүхний эзэмшиж байгаа хувьцааны үнийг нэмэгдүүлнэ. 18.3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байсан компани өнөөдөр 200 гаруй тэрбум төгрөгийн үнэлгээтэй компани болоод 10 гаруй дахин өсөж чадсан. Дахиад хэд дахин өсөх тухай бол ярих нь хэтэрхий хариуцлагагүй зүйл байх. Гэхдээ Говь ХК удахгүй 2.3 саяын хүчин чадлаа бүрэн ашиглана. Цаашлаад 10 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлээд дэлхийд Монгол ноолуураар Монголыг таниулдаг брэнд болохын төлөө манай хамт олон ажиллах болно. Та бүхэнд шүүмжлэх, асуух зүйл байвал ганц өдрийн хурал хангалтгүй байна. ТУЗ-ийн даргын хэлсэнчлэн асуудал байвал ТУЗ-ийн нарийн бичиг Сэлэнгэ гэж хүнтэй холбогдоод санал хүсэлтээ өгөөрэй. Тэр дундаас бид зөв зүйтэй санал хүсэлтийг шүүж аваад та бүхэнтэй эргэх холбоотой хамтарч ажиллана.

**ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:** Баярлалаа. Үүгээр манай асуулт хариултын хэсэг өндөрлөж байна. Цагаасаа бага зэрэг хэтэрлээ. Одоо ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ санал өгөх зааварчилгааг танилцуулна.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ:** Та бүхний саналын хуудасны ард санал хүсэлт бичих хэсэг байгаа, тэнд та бүхэн санал хүсэлт асуултаа бичээд өгнө үү, бид бүхэн эргээд холбогдоно. Одоо та бүхэнд саналын хуудсаа бөглөхөд нь зориулаад товч тайлбар өгье. Саналын хуудас дээр овог нэр, регистрийн дугаараа бичээд, эзэмшиж буй хувьцааны тоогоо шалгаарай. Орж ирэхэд нь манай тооллогын комисс хувьцааны тоог нь бичиж өгсөн гэж бодож байна. Энэ хурлаас нэг асуудал дээр санал хураалт явуулна. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг Гэрэлмаа дарга танилцуулсан. Энэхүү дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа эсэх дээр саналаа өгнө. Зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн гурван нүдэнд зөвлөсөн тэмдэглэгээ тавина. Доор нь он сараа бичээд гарын үсгээ баталгаажуулах байгаа. Зөв тэмдгээс өөрөөр тэмдэглэсэн мөн нэгээс илүү нүдэнд тэмдэглэсэн бол таны санал хүчингүйд тооцогдох учир та бүхэн анхааралтай бөглөнө үү.

## 6. САНАЛ ХУРААЛТ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа санал хураалтыг албан ёсоор нээж нийт санал хураалт нийт 10 минут үргэлжлэв.



## 7. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс саналын хайрцгийг задлан, санал хураалтын дүнг нэгтгэв. Нийт 15 минут үргэлжлэв.

## 8. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

*Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн ТОГТООХ нь:

- Нэг.** Санал хураах хайрцгаар **51.98** хувийн саналын эрхтэй **405,499,195** ширхэг хувьцааны **90** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
- Хоёр.** Шуудангаар дамжуулж дамжуулж **34.00** хувийн саналын эрхтэй **265,238,300** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.
- Гурав.** Брокерын пүүсүүдээр дамжуулж **2.39** хувийн саналын эрхтэй **18,674,878** ширхэг хувьцааны **2** ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.
- Дөрөв.** Компанийн байранд **0.08** хувийн саналын эрхтэй **625,685** ширхэг хувьцааны **1,043** ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.
- Тав.** Нийт саналын хуудаснаас **0.00** хувийн саналын эрхтэй **33,250** ширхэг хувьцааны **19** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.
- Зургаа.** Говь ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Тооллогын комиссын дарга  
Нарийн бичгийн дарга  
Гишүүд

Н.Сайнзул  
Ц.Цэцэгбадам  
Н.Мөнхзул  
Б.Уянга  
Г.Ганзаяа  
Г.Золзаяа

## 9. ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.*

***Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай***

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

**Нэг.** Говь ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

## ХУРЛЫН ДАРГА Д.ГЭРЭЛМАА

*Хавсралт 1:*

### ГОВЬ ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2021 оны бизнес төлөвлөгөө нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 70 хувь өсгөх, бараа материалын удирдлагын тогтолцоог сайжруулан нийт бараа материалын эргэц хоногийг 30 хувиар бууруулах, үйл ажиллагааны тогтвортой, эрсдэлгүй байдлыг хангах үүднээс урт хугацааны тогтвортой мэдээлэл технологийн бүтэц бүхий "SAP B1" программыг нэвтрүүлэх, зах зээл төвтэй сэтгэл зүйн хандлагыг бүх ажилтнуудад хэвшүүлэх замаар компанийн зах зээлд эзлэх байр суурь болон ашигт ажиллагааг өсгөхөд тус тус чиглэсэн билээ.

Говь ХК нь 2021 онд ажилтнуудынхаа эрүүл мэндийг нэн тэргүүнд чухалчилж УОК, НОК-ийн зөвлөмж, чиглүүлгийг чанд мөрдөн үйлдвэрлэл, борлуулалтынхаа үйл ажиллагааг тасралтгүй явуулж ажилласан хэдий ч манай үйл ажиллагаанд үзүүлэх цар тахлын нөлөө байсаар байна. Бид ирээдүйн урт хугацааны хөгжил дэвшлийг том зургаар харан, олон улсын зах зээлд илүү танигдах, өрсөлдөх, дэлхийн брэнд болох зорилгоор сүүлийн гурван жилийн хугацаанд стратегийн томоохон хөрөнгө оруулалтуудыг хийлээ. Үүгээрээ бид ирээдүйн өсөлт дэвшлийнхээ суурийг сайн бэлтгэж чадсан гэж дүгнэж байна.

Санхүүгийн үр дүнгийн хувьд 2021 онд 144.3 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 72 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 23 хувь өссөн үзүүлэлттэй гарлаа. Гадаад борлуулалт 2021 онд 36.8 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 102 хувь, өмнөх оноос 2 хувь өссөн, дотоод борлуулалт 66.6 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 116 хувь, өмнөх оноос 35 хувь өссөн, онлайн борлуулалт 40.9 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 38 хувь, өмнөх оноос 29 хувь тус тус өссөн үр дүнд хүрчээ. Дэлхийн зах зээлийг чиглэн борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 2 дугаар хагас жилээс эхлүүлсэн онлайн



борлуулалт маань өдгөө 4.2 дахин өсөлтийг үзүүлсэн нь сүүлийн жилүүдэд хийсэн томоохон хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг хүртэх цаг ойртсоор байгааг илтгэж байна.

Тайлант жилд шинээр түүхий эд татан аваагүй бөгөөд нөөцөө бууруулах арга хэмжээг авч ажиллан, бараа материалын эргэцийг 26 хувь бууруулж чадсан. Мэдээллийн технологийг хөгжүүлэх, программчлал болон цахим шилжилтийг хийх ажлын хүрээнд Европын охин компанид SAP B1 программыг амжилттай нэвтрүүлж дууссан бөгөөд мэдээлэл технологийн багийнхан маань дотооддоо Codely программыг хөгжүүлэн нэвтрүүлж үйлдвэрлэл болон үйл ажиллагааны хүрээнд автоматжуулалтыг шат дараатайгаар хийн, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж чадлаа.

Энэ онд нийт 644 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 40 сая төгрөг буюу 6 хувь нь барилга байгууламж, 116 сая төгрөг буюу 18 хувь нь тоног төхөөрөмж, 211 сая төгрөг буюу 33 хувь нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгө оруулалтад, 277 сая төгрөг буюу 43 хувь нь биет бус хөрөнгө оруулалтад зарцуулагдсан байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

## ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ХУРЛЫН ХААЛТ

*ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа:* Баярлалаа. Үүгээр манай хурлын үйл ажиллагаа өндөрлөж байна. Хурлын тогтоолоо бид бүхэн баталлаа. Хуралдаа хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсье. Хариуцлагатай байсанд талархаж байна. Хурлыг хаасныг мэдэгдье. Баярлалаа.

Хурал 13 цаг 00 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

ТУЗ-ийн дарга



Д.ГЭРЭЛМАА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн мэргэжилтэн



Б.НАРАНТУЯА